БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН БИЗНЕС ИННОВАЦ ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.БАТ-ӨЛЗИЙ

ГҮҮГЛ СТРИЙТ ВЬЮ (ГУДАМЖ, ТАЛБАЙН ЗУРГИЙГ ХАЯГЫН МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ СИСТЕМД ОРУУЛАХ) АЖЛЫН ДААЛГАВАР

Тендер шалгаруулалтын нэр:	Гүүгл стрийт вью (Гудамж, талбайн зургийг хаягын мэдээллийн нээлттэй системд оруулах)
Тендер шалгаруулалтын дугаар:	БИХГ/202310001

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

АГУУЛГА

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Захиалагч
2. Үндэслэл
3. Зорилго
4. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх зорилт
5. Оролцогч тал
6. Хамрах хүрээ
7. Төслийн үр дүн

Б. ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДАРААЛАЛ

1. Нийслэлийн 9 дүүргийн гудамж талбайн зургийг шинэчлэх
2. Нийслэлийн төрийн байгууллагуудын бизнес мэдээллийг шинэчлэх, иргэд олон нийтийг бодит мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх
3. Нийслэлийн зарим төрийн байгууллагуудын дотор зураг авалтыг хийх, иргэд олон нийтийг бодит мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх
4. Нийслэлийн 9 дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчдийн бизнес мэдээллийг газрын зурагт шинэчлэх

В. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ:

1. Гудамжны зураг авалт (Google User Street View)
2. Гүүгл бизнес (Google my business)
3. Дотор зураг авалт (Google Inside View)

Г. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

1. Гүүгл стрийт вью (google street view) зураг авалт хийх тоног төхөөрөмжид тавих шаардлага
2. Гүйцэтгэгчид тавигдах тусгай шаардлага
3. Тайланд тавих шаардлага

А.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

№	Ерөнхий мэдээлэл	
1	Захиалагч	Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газар
2	Үндэслэл	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр • 4.1.4-т тусгагдсан "Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ." МУ-ын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол "Шинэ сэргэлтийн бодлого" • 3.6-т Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр • 3.2-т Хотыг үйлдвэрлэл, инновацын төв болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ. • 3.2.1-т Нийслэлд инновацын соёлыг бий болгох, түгээх нийслэлийн инновацыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/558 дугаар захирамж, Нийслэлийн бизнес инновацыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө • 5-р бүлэг буюу Олон улсын хамтын ажиллагаа /Networking/ Инновац, гарааны бизнесийг хөгжүүлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, Улаанбаатар

		хотын ах дүү, найрамдалт, харилцаат хотууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах гэсний 5.5-т Бизнесүүдийг дэмжих, чанар хүртээмжийг сайжруулах "google business" төслийг хэрэгжүүлнэ.., гэжээ.
3	Зорилго	Улаанбаатар хотыг дэлхий нийтэд сурталчлах, бизнес, аялал жуулчлалыг дэмжих, олон нийтэд таниулах замаар бизнесийн байгууллагуудын бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт, ашиг орлогыг нэмэгдүүлэх
4	Төслийн хүрээнд хэрэгжүүлэх зорилт	➢ Нийслэлийн 9 дүүргийн гудамж талбайн зургийг шинэчлэх; ➢ Нийслэлийн төрийн байгууллагуудын бизнес мэдээллийг шинэчлэх, иргэд олон нийтийг бодит мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх; ➢ Нийслэлийн зарим төрийн байгууллагуудын дотор зураг авалтыг хийх, иргэд олон нийтийг бодит мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх; ➢ Нийслэлийн зарим жижиг дунд бизнес эрхлэгчдийн бизнес мэдээллийг шинэчлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт, ашиг орлогыг нэмэгдүүлэх, олон улсад сурталчлах;
5	Оролцогч тал	➢ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар ➢ Нийслэлийн төр захиргааны байгууллагууд ➢ Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газар

		➢ Иргэн, аж ахуйн нэгж ➢ Бусад
6	Хамрах хүрээ	➢ Баянзүрх дүүрэг ➢ Хан-Уул дүүрэг ➢ Сонгинохайрхан дүүрэг ➢ Сүхбаатар дүүрэг ➢ Чингэлтэй дүүрэг ➢ Баянгол дүүрэг ➢ Налайх дүүрэг ➢ Багануур дүүрэг ➢ Багахангай дүүрэг
7	Төслийн үр дүн	➢ Иргэд, олон нийт очих газраа виртуалаар урьдчилан харж, шийдвэр гаргах, дүн шинжилгээ хийх боломжоор хангана. ➢ Нийслэлийн төрийн байгууллагуудын бодит мэдээллийг харах боломж бүрдэнэ. ➢ Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулж, хэрэглэгчидтэй харилцах харилцаагаа сайжруулах, зорилтот хэрэглэгчиддээ хүрэх боломжийг олгож, бизнесийн ашиг орлогыг нэмэгдүүлнэ. ➢ Улаанбаатар хотыг дэлхий нийтэд сурталчилж, жуулчдад ойлгомжтой зураглалыг харуулж, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Б. ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДАРААЛАЛ

1.Нийслэлийн 9 дүүргийн гудамж талбайн зургийг шинэчлэх:

- Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэр дэх хатуу хучилттай замын судалгааг нарийвчлан гаргах;
- Зураг авалтыг гүүглийн төлөвлөлтийн программаар төлөвлөх (2500 км)
- Төлөвлөгдсөн маршрутын дагуу зураг авалт хийх (2500 км);
- Зурган өгөгдлийг гүүгл платформд байршуулах боловсруулалт хийх;
- Зурган өгөгдлийг зөөврийн хард диск дээр байршуулж гүүгл компани руу илгээмжээр илгээх;

2. Нийслэлийн төрийн байгууллагуудын бизнес мэдээллийг шинэчлэх, иргэд олон нийтийг бодит мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх:

- Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;
- Нийслэлийн 9 дүүрэг, 204 хороо, өрхийн эмнэлэгийн мэдээллийг оруулж, олон нийтийг мэдээллээр хангах;

3. Нийслэлийн зарим төрийн байгууллагуудын дотор зураг авалтыг хийх, иргэд олон нийтийг бодит мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх:

- Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар-5;
- Мишээл, драгон, баянгол, оргил, баянхошуу зэрэг НҮНТ-5;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар;
- Шинэ яармаг дахь Хангарди ордон;

4. Нийслэлийн 9 дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчдийн бизнес мэдээллийг газрын зурагт шинэчлэх:

- Жижиг, дунд бизнес эрхлэгч-700;

В.ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

№	Төслийн нэр	Хийгдэх ажил	Зорилт	Тоо хэмжээ	Хурд (км/цаг)	Панарома зургийн тоо
1	Гудамжны зураг авалт (Google User Street View)	Нийслэлийн 9 дүүргийн гудамж, талбайн зургийг шинэчлэх зураг авах	Гол болон туслах зам, алслагдсан хороодын хатуу хучилттай замууд	2500км	12	750,000
		Аялалын маршрут	1.Богдхан уулын Зайсан-Баруун ширээт чиглэлийн явган аяллын зам /5км/ 2.Богдхан уулын Төр хурах-Цэцээ гүн явган аяллын зам /8,5км/ 3.Чингэлтэй хайрхан уулын явган аяллын зам /4,5км/ 4.Сонгинохайрхан уулын явган аяллын зам /5,5км/ 5.Баянзүрх хайрханы явган аяллын зам /7км/	30.5км	2.5	43,920
2	Гүүгл бизнес (Google my business)	Төрийн болон бизнесийн байгууллагуудыг Googlemapd бүртгүүлэх сургалтыг зохион байгуулах	1.Төрийн байгууллагууд 2.Нийслэлийн өрхийн эмнэлгүүд 3.ЖДҮ эрхлэгчид	912ш	-	-
3	Дотор зураг авалт (Google Inside View)	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд	Мишээл Драгон Баянгол Оргил Баянхошуу	5ш	-	65,200
		Нийслэлийн Засаг захиргааны байрууд	НЗДТГ, Яармаг дахь Хангарди ордон 5 дүүргийн ЗДТГ	7ш	-	91,280
НИЙТ:						**950,400**

Г. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Модулиуд	Ерөнхий шаардлага
Гүүгл стрийт вью (google street view) зураг авалт хийх тоног төхөөрөмжид тавих шаардлага	Google street view-ийн техникийн стандарт шаардлагад нийцсэн байх;
	Камер нь тус бүр нь 20 мегапикселийн мэдрэгч бүхий долоон тусдаа камертай буюу 140 мегапикселийн панорам зураг авах боломжтой байх (1 секундэд 7 зураг буюу 1 панарома зураг авах боломжтой байх);
	Lidar мэдрэгч (миллметрийн нарийвчлал)-тэй байх;
	Гудамжны зураглалын маршрутыг урьдчилан төлөвлөх системтэй байх;
	Төхөөрөмж дээрээ Google-тэй шууд холбогдох GPS-тэй байх;
	Төхөөрөмж дээрээ лазер сканнертай байх;
	Төхөөрөмж дээрээ боловсруулах төхөөрөмж (processing unit)-тэй байх;
	Төхөөрөмж дээрээ дулаан шингээгчтэй байх;
	Автомашин дээр суурилуулах зориулалтын хөлтэй байх;
	Явганаар зураг авахад зориулсан зориулалтын үүргэвчтэй байх;
	Төхөөрөмжийн нийт жин 20 кг-аас ихгүй байх;
	Цаг агаарын нөхцлийг мэдрэх чадвартай байх;
	Зурган өгөгдлийг хадгалах 3TB-аас дээш хатуу дисктай байх (10 ширхэгээс дээш);
	5 цагаас дээш тасралтгүй бичлэг хийх тэжээлтэй (батарей) байх ба 2-оос доошгүй нөөцтэй байх;
Гүйцэтгэгчид тавигдах тусгай шаардлага	Гүүгл стрийт вью (google street view)-д хөгжүүлэлт хийх тусгай багтай байх;
	Гүүгл стрийт вью (google street view) зураг авалт хийх 2 ба түүнээс дээш тооны гүүгл треккер (google trekker) төхөөрөмжтэй байх (2018 оноос хойш үйлдвэрлэсэн);

	Зураг авалт хийх мэргэжилтэн тусгай сургалтад сууж мэргэжил дээшлүүлсэн байх (төхөөрөмж, программ хангамж, камертай ажилах);
Тайланд тавих шаардлага	Явцын тайланд захиалагч байгууллагаас гаргасан саналын хүрээнд гудамж, талбайн зураг авалтын ажлын явцын гүйцэтгэлийг тайланд оруулсан байх;
	Төгсгөлийн тайланд захиалагч байгууллагын санал, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэсэн ажлын биелэлтийг актын хамт хүлээлгэн өгөх.

--o0o--